

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр, Лхагва гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга 0

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-4

1. Байнгын хорооны даргыг сонгох тухай 3-4

**Монгол Улсын Их Хурлын ес дэх удаагийн бүрэн эрхийн анхдугаар чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 06 цаг 36 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: С.Бямбацогт, Л.Гантөмөр, Т.Доржханд, Н.Номтойбаяр, Э.Одбаяр, Л.Оюун-Эрдэнэ, Ц.Туваан, Н.Учрал, О.Цогтгэрэл, Ө.Шижир, Л.Энх-Амгалан.

Нэг.Байнгын хорооны даргыг сонгох тухай

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн, Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Л.Мөнхбаатар Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлсэн талаар танилцуулав.

Нэр дэвшигчээс болон танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4-т заасны дагуу санал хураалтыг гар өргөж явуулав.

Ц.Сандаг-Очир: Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнийг сонгохыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 2
Бүгд: 14
85.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баярбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 06 цаг 40 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 04 минут үргэлжилж, 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 06 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХУРАЛДААН ДАРГАЛАГЧ,
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

Ц.САНДАГ-ОЧИР

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ ХӨТЛӨХ
АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 оны 07 дугаар сарын 10-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим, 06 цаг 36 минут

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ**

Ц.Сандаг-Очир: Төрийн байгуулалтын байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, ирц бүрдсэн тул Төрийн байгуулалтын байнгын хорооны 2024 оны 7 сарын 10-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудал батлагдлаа.

Улсын Их Хурал дахь Монгол Ардын намын бүлгийн дарга Лхагвын Мөнхбаатар Байнгын хорооны даргад нэр дэвшүүлнэ. Мөнхбаатар дарга таныг танилцуулгаа хийнэ үү гэж урьж байна. Мөнхбаатар даргын микрофоныг өгөөрэй.

Л.Мөнхбаатар: Байнгын хорооны эрхэм гишүүдийн амрыг эрье.

Монгол Ардын намын бүлгээс Улсын Их Хурлын гишүүн Жадамбын Бат-Эрдэнийг Байнгын хорооны даргад нэр дэвшүүлж байна. Товч намтрыг уншиж танилцуулъя. Жадамбын Бат-Эрдэнэ 1983 онд нийслэлийн 75 дугаар дунд сургууль, 1989 онд Оросын Холбооны Улсын Эрхүү хотын Политехникийн дээд сургууль, 1998 онд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн

сургуулийг Эрх зүйч мэргэжлээр тус тус төгссөн байна.

1990-1992 онд Оросын Холбооны Улсад Рыпкооп улсын үйлдвэрийн газарт менежер, 1994-2000 онд “Ашид Эрдэнэ” компанийн захирал, 2000-2004 онд Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Авто тээврийн газрын дарга, 2007-2012 онд Зам, тээвэр, аялал жуулчлалын яамны Төрийн нарийн бичгийн дарга, 2008-2012 онд “Монголын Төмөр зам” төрийн өмчит компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, 2011-2012 онд “МИАТ” компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, 2013-2016 онд Булган аймгийн Монгол Ардын намын хорооны дарга, 2016 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүн, 2017-2018 онд Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Зам, тээврийн хөгжлийн сайд, 2019 оноос Жижиг, дунд үйлдвэрлэлийн хөгжлийн дэд хорооны дарга, 2020-2024 онд Улсын Их Хурлын гишүүн, 2024 оноос Монгол Улсын Их Хурлын гишүүнээр сонгогдон ажиллаж байна.

Та бүхэн Жадамбын Бат-Эрдэнийг Төрийн байгуулалтын байнгын хорооны даргаар томилж өгөхийг та бүгдээс хүсье. Баярлалаа.

Ц.Сандаг-Очир: Мөнхбаатар даргад баярлалаа. Байнгын хорооны даргад нэр дэвшигчээс асуух асуулттай гишүүн байна уу. Байнгын хорооны даргад нэр дэвшигчээс асуух асуулт байхгүй байна. Үг хэлэх гишүүд байна уу. Алга байна. Гишүүд асуулт асууж, үг хэлж дууслаа.

Улсын Их Хурлын гишүүн Жадамба овогтой Бат-Эрдэнийг Төрийн байгуулалтын байнгын хорооны даргад нэр дэвшүүлэх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураана. Санал хураалтыг илээр гараа өргөж хураана. 14-12 дэмжсэн байна.

Байнгын хорооны даргад
Жадамбын Бат-Эрдэнийг олонхын
саналаар дэмжлээ.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг
Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн
хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн
Баярбаатар танилцуулна.

Хэлэлцэх асуудал дууссан тул
өнөөдрийн Төрийн байгуулалтын байнгын
хорооны хуралдааныг хаасныг мэдэгдье.
Баярлалаа.

06.40 цаг.

Дууны бичлэгээс буулгасан:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ